



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Хүүхдийн есдүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СБА-2025/115/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт сум

2025 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер: М.Нарантуяа

Утас: 99029193 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Аудитор: Б. Бүзмаа

Утас: 91160110 Цахим хаяг: Buzmaa@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....</b>	<b>5</b>
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>10</b>
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>11</b>

---

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,  
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,  
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075  
Утас: (976) 70518396  
Цахим шуудан: [sukhbaatar@audit.gov.mn](mailto:sukhbaatar@audit.gov.mn)

2025.02.25 № 159

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2024 онд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 111,096.6 мянган төгрөг, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,221,652.7 мянган төгрөг, үүний 1,123,469.0 мянган төгрөг улсын төсвөөс, 98,183.7 мянган төгрөг орон нутгийн төсвөөс санхүүжихээр төлөвлөсөн, өмнөх оны санхүүжилтын гүйцэтгэлээс 219,465.9 мянган төгрөгөөр өссөн буюу 1,031,152.3 мянган төгрөг байгааг тайланд толилуулсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлыг тодорхойлоход материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн үнэлгээ өндөр, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын шийдвэр гаргасан чухал асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал гараагүй болно.

## **Бусад асуудал**

2024-2025 оны хичээлийн жилд 267 хүүхэд хамрагдахаас 267 хүүхэд хамрагдаж хамрагдалтын хувь 100 хувьтай байна.

Сүхбаатар аймгийн Боловсролын газрын даргатай хийсэн 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 4 зорилтот хөтөлбөрийн 33 арга хэмжээний биелэлт 89.4 хувиар дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Г.ДАВАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>181,871,090.16</b>	<b>261,612,061.53</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	111,096,609.82	185,065,377.03
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	111,096,609.82	185,065,377.03
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	111,096,609.82	185,065,377.03
31211	Төрийн сангийн харилцах	111,096,609.82	185,065,377.03
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	52,000.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	52,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	70,722,480.34	76,546,684.50
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	167,850.00	167,850.00
35130	Эм боох материал	167,850.00	167,850.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	70,554,630.34	76,378,834.50
35410	Бичиг хэргийн материал	897,500.00	549,500.00
35420	Аж ахуйн материал	34,900.00	-
35450	Барилгын засварын материал	370,200.00	454,200.00
35460	Хүнсний материал	216,350.00	260,354.00
35470	Бусад хангамжийн материал	69,035,680.34	75,114,780.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>164,251,249.77</b>	<b>137,454,770.95</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	164,251,249.77	137,454,770.95
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	142,086,249.82	115,789,771.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	148,838,516.49	148,838,516.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	(57,641,133.00)	(69,169,359.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50,122,065.00	53,751,765.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,546,679.01)	(30,814,267.02)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,601,254.00	53,091,254.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,530,623.66)	(42,424,987.83)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,726,850.00	3,726,850.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(484,000.00)	(1,210,000.00)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	22,164,999.95	21,664,999.91
39301	Програм хангамж	2,270,000.00	2,270,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,395,000.05)	(1,895,000.09)
39303	Бусад биет бус хөрөнгө	21,290,000.00	21,290,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>346,122,339.93</b>	<b>399,066,832.48</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>630,000.00</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	630,000.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	630,000.00	-
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	630,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>345,492,339.93</b>	<b>399,066,832.48</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	345,492,339.93	399,066,832.48
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	25,548,000.00	25,548,000.00
51101	Өмч: - төрийн	25,548,000.00	25,548,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	267,142,170.60	320,716,663.15
51210	Өмнөх үеийн үр дүн	156,286,638.36	267,142,170.60
51220	Тайлант үеийн үр дүн	110,855,532.24	53,574,492.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	52,802,169.33	52,802,169.33
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>346,122,339.93</b>	<b>399,066,832.48</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>885,655,208.50</b>	<b>1,105,121,100.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>37,639,008.50</b>	<b>200,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	37,639,008.50	200,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	37,639,008.50	200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,400,000.00	200,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	32,239,008.50	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>848,016,200.00</b>	<b>1,104,921,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	764,460,000.00	1,007,263,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	764,460,000.00	1,007,263,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	83,556,200.00	97,657,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	83,556,200.00	92,157,900.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	5,500,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>774,799,676.26</b>	<b>1,051,546,607.45</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>774,799,676.26</b>	<b>1,051,546,607.45</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	770,766,117.66	1,050,075,806.08
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	495,433,522.18	706,816,523.22
210101	Үндсэн цалин	355,009,341.46	467,956,159.91
210102	Нэмэгдэл	121,634,518.22	218,357,458.15
210104	Урамшуулал	18,789,662.50	20,502,905.16
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	63,719,327.18	88,992,700.42
210201	Тэтгэврийн даатгал	43,433,385.40	61,572,891.04
210202	Тэтгэмжийн даатгал	5,107,075.98	7,105,100.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,522,438.34	3,523,626.16
210204	Ажилгүйдлийн даатгал	968,041.46	3,299,138.58
210205	Эрүүл мэндийн даатгал	9,688,386.00	13,491,944.35
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	68,140,385.62	75,687,098.63
210301	Гэрэл, цахилгаан	5,757,602.38	6,317,992.01
210302	Түлш, халаалт	55,528,683.24	58,407,606.62
210303	Цэвэр, бохир ус	6,854,100.00	10,961,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,251,224.00	28,579,749.84
210401	Бичиг хэрэг	3,005,900.00	8,527,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,289,600.00	4,415,350.00
210408	Бараа материал акталсны зардал	6,955,724.00	15,637,099.84
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	84,763,653.00	101,903,005.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	208,350.00	503,906.00
210502	Хоол, хүнс	84,555,303.00	101,399,099.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,122,500.00	4,774,700.00
210604	Урсгал засвар	8,122,500.00	4,774,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,248,104.00	1,542,700.30
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,248,104.00	1,542,700.30
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	37,087,401.68	41,779,328.67

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,532,560.00	7,863,149.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,496,800.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,058,041.68	33,916,178.82
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,033,558.60</b>	<b>1,470,801.37</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>4,033,558.60</b>	<b>1,470,801.37</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,033,558.60	1,470,801.37
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>110,855,532.24</b>	<b>53,574,492.55</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>110,855,532.24</b>	<b>53,574,492.55</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>853,416,200.00</b>	<b>1,105,121,100.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,400,000.00</b>	<b>200,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,400,000.00	200,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	5,400,000.00	200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,400,000.00	200,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>848,016,200.00</b>	<b>1,104,921,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	764,460,000.00	1,007,263,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	764,460,000.00	1,007,263,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	83,556,200.00	97,657,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	83,556,200.00	92,157,900.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	5,500,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>746,786,135.36</b>	<b>1,024,032,632.79</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>746,786,135.36</b>	<b>1,024,032,632.79</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>742,752,576.76</b>	<b>1,022,561,831.42</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	495,719,228.19	706,764,523.22
210101	Үндсэн цалин	355,301,680.49	467,976,550.31
210102	Нэмэгдэл	121,627,885.20	218,285,067.75
210104	Урамшуулал	18,789,662.50	20,502,905.16
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	63,485,621.17	88,992,700.42
210201	Тэтгэврийн даатгал	43,266,907.39	61,572,891.04
210202	Тэтгэмжийн даатгал	5,090,268.98	7,105,100.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,508,992.34	3,523,626.16
210204	Ажилгүйдлийн даатгал	964,679.96	3,299,138.58
210205	Эрүүл мэндийн даатгал	9,654,772.50	13,491,944.35
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	68,992,641.40	75,687,098.63
210301	Гэрэл, цахилгаан	5,757,602.38	6,317,992.01
210302	Түлш, халаалт	55,528,683.24	57,879,826.62
210303	Цэвэр, бохир ус	7,706,355.78	11,489,280.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	83,824,786.00	101,443,853.00
210502	Хоол, хүнс	83,824,786.00	101,443,853.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,900,000.00	15,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	10,000,000.00
210604	Урсгал засвар	6,900,000.00	5,000,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,398,104.00	1,992,700.30
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,398,104.00	1,992,700.30
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	22,432,196.00	32,680,955.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,231,296.00	23,088,955.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,200,900.00	9,592,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,033,558.60</b>	<b>1,470,801.37</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	4,033,558.60	1,470,801.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,033,558.60	1,470,801.37
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>106,630,064.64</b>	<b>81,088,467.21</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,930,000.00</b>	<b>7,119,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,930,000.00</b>	<b>7,119,700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	6,930,000.00	7,119,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,930,000.00	7,119,700.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-6,930,000.00</b>	<b>-7,119,700.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	99,700,064.64	73,968,767.21
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	11,396,545.18	111,096,609.82
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	111,096,609.82	185,065,377.03

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	25,548,000.00	52,802,169.33	156,286,638.36	234,636,807.69
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>25,548,000.00</b>	<b>52,802,169.33</b>	<b>156,286,638.36</b>	<b>234,636,807.69</b>
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	110,855,532.24	110,855,532.24
C08	<b>2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>25,548,000.00</b>	<b>52,802,169.33</b>	<b>267,142,170.60</b>	<b>346,122,339.93</b>
D01	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>25,548,000.00</b>	<b>52,802,169.33</b>	<b>267,142,170.60</b>	<b>346,122,339.93</b>
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	53,574,492.55	53,574,492.55
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>25,548,000.00</b>	<b>52,802,169.33</b>	<b>320,716,663.15</b>	<b>399,066,832.48</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,221,652,700.00	1,029,681,531.42
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,221,652,700.00	1,029,681,531.42
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,221,652,700.00	1,029,681,531.42
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	865,665,200.00	706,764,523.22
210101	Үндсэн цалин	620,999,700.00	467,976,550.31
210102	Нэмэгдэл	241,415,900.00	218,285,067.75
210104	Урамшуулал	3,249,600.00	20,502,905.16
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	99,696,000.00	88,992,700.42
210201	Тэтгэврийн даатгал	67,795,300.00	61,572,891.04
210202	Тэтгэмжийн даатгал	7,973,500.00	7,105,100.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,987,800.00	3,523,626.16
210204	Ажилгүйдлийн даатгал	3,987,800.00	3,299,138.58
210205	Эрүүл мэндийн даатгал	15,951,600.00	13,491,944.35
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	83,183,700.00	75,687,098.63
210301	Гэрэл, цахилгаан	6,000,000.00	6,317,992.01
210302	Түлш, халаалт	64,813,200.00	57,879,826.62
210303	Цэвэр, бохир ус	12,370,500.00	11,489,280.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	111,764,700.00	101,443,853.00
210502	Хоол, хүнс	111,764,700.00	101,443,853.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15,000,000.00	15,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,162,700.00	1,992,700.30
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,162,700.00	1,992,700.30
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	43,180,400.00	39,800,655.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,588,400.00	30,208,655.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,592,000.00	9,592,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,114,719,100.00	1,099,421,100.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,114,719,100.00	1,099,421,100.00
122005	Орон нутгийн төсвөөс	1,114,719,100.00	1,099,421,100.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	111,096,609.82
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	185,065,377.03

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2.4 сая төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 2.4 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн. Нийт илрүүлсэн 2.4 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

#### 3.1 Албан шаардлага

##### Илрүүлэлт:

Цалингийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг 2 албан хаагчид нийт 2,360.9 мянган төгрөгийн цалингийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг давхардуулан олгосон зөрчилтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 (батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах), 41 дүгээр зүйлийн 41.2.2 (батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах), 41.2 дахь хэсгийн 41.2.3 (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах), Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6 (харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1 (Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно), 12.1.4 (хуулиар зөвшөөрөөгүй бусад), Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан (Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын хавсралт), 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан (Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх) журмыг тус тус зөрчсөн байна.

#### 3.2 Зөвлөмж

##### Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 48 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т (Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна, үүнд 6.2.1-д (Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон), “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан тогтоох асуудлыг судлан, элэгдлээрээ бүрэн нөхөгдсөн хөрөнгийг ашиглалтын боломжит байдлыг харгалзан дахин үнэлэх асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх, Мөн

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шаардлагатай тохиолдолд Орон нутгийн өмчийн газартай зөвшилцөн данснаас хасах шийдвэрийг гаргуулах томьёолол бэлтгэн, санхүүгийн тайланд бодитой тусгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт- ны тоо	Тоо	Дүн	
Ур чадварын нэмэгдлийг 2 ажилтанд давхардуулан олгосон	1	2,360.9			1	2,360.9							
Анхны өртгөө нөхсөн 48 ш үндсэн хөрөнгө бүртгэлд байна.	1	-					1	-					
Дүн	2	2,360.9			1	2,360.9	1	-					